

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-27
1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	8-9
2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-17
3.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	17-20
4.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	20-25
5.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/	25-26
6.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг төрийн бус байгууллагуудын саналаас сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	26-27

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
12 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар, Ж.Батжаргал, С.Бямбацогт, Ц.Туваан;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, А.Ариунзаяа, Л.Гантөмөр, Т.Доржханд, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгээрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Л.Мөнхбаатар.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 10 гишүүнээс 2025.11.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 41 гишүүнээс 2025.11.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газраас 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17

47.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 15 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, С.Зулпхар, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “давхацсан бол” гэсний дараа “долоо хоног бүрийн амралтын” гэж нэмж, төслийн тайлбарыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8

Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин үг хэлэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны

ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	8
Бүгд:	17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Сандаг-Очир: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	7
Бүгд:	17

58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг төрийн

бус байгууллагуудын саналаас сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу санал хэлэв.

Ц.Сандаг-Очир: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 22 минут.*

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Жудагийн Баярмаа гишүүн ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа нарын 17 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дэх хэлэлцэх асуудал Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал. 2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ. 3. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025 оны 6 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг хийнэ. 4. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. 5. Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. 6. Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай гэсэн 6 хэлэлцэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орно. Гишүүдийг дуудаарай. Санал хураалт, гишүүд танхимдаа гишүүд танхимдаа ирэхийг хүсэж байна. Ирцдээ орсон гишүүдийг хуралдаа орохыг урьж байна. Танхимд хүрэлцэн ирэхийг хүсэж байна. Санал хураалт явагдах гэж байна. Энэ Евроазийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай асуудал өнөөдөр манай Байнгын хороогоор орж байж, дараа нь маргааш Аюулгүй байдлаар орно. Ингээд чуулганаар орох цаг хугацаатай асуудал чухал, хууль байгаа учраас манай Байнгын хорооны гишүүдийг ирцдээ орсон гишүүдийг санал хураалтдаа орж ирэхийг урьж

байна. Ажлын албаныхан гишүүдийг дуудаарай. Ирцдээ орсон гишүүд санал хураалтад.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Санал хураалт. Хэлэлцэх асуудалдаа орно. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй байгаа хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналын өмнө харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Энэ чинь хаанаас харах билээ жагсаалтад орсныг нь санал хураалтад бэлдсэнээ, эндээс чинь. Болсон байна, 9 гишүүн байна.

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын Улсын Их Хурлын 10 гишүүнээс 2025 оны 11 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын Улсын Их Хурлын 41 гишүүнээс 2025 оны 11 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 52,9 хувиар санал дэмжигдлээ.

3.Засгийн газрын 2025 оны 11 сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д заасан хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Уначихлаа шүү дээ 47, 8 хүн. Баярбаатар гишүүн горимын санал гаргана даа. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Би харин өөрийн буруугаас болоод санал хураалтаасаа хоцорчихлоо. Тэгээд санал хураалтыг хүчингүй болгож, дахиж хураалгаж өгөх горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Саяын санал хураалтыг Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Баярбаатар гишүүний гаргасан саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явагдаж ахиад уначихлаа шүү дээ. Баярбаатар гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй учраас Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах асуудал дэмжигдсэнгүй. Уг нь их чухал хууль байсан юм гишүүдээ. Манай Байнгын хороонд нэг их сайд байхгүй. Хэн байгаа юм бэ? Бямбацогт сайдаас бусад нь ерөөсөө гаргачихсан шүү дээ Засгийн газрын гишүүдийг байлгахгүй гээд. 1 дэх асуудал хэлэлцэж дууслаа. Та горим гаргаж болохгүй юм байна.

15.50 цаг

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

2 дахь асуудалдаа оръё. Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын Улсын Их Хурлын 8 гишүүний 2025 оны 7 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр хийнэ. Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

У.Отгонбаяр: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн найруулгыг баталж, 2022 оны 1 сарын 1-ний өдрөөс даган мөрдөж эхэлсэн билээ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт иргэн, Монгол Улсын иргэн, иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн ес дэх хэсэгт заасны дагуу шууд болон төлөөллийн байгууллагаараа уламжлан нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй гэж зааснаар шат шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тухайн орон нутгийн нийт иргэд, сонгогчдын төлөөллийн байгууллага юм.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, төлөөллийн байгууллагаараа дамжуулан нутгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхийг хуульчилж өгсөн атлаа шат шатны иргэдийн төлөөлөгч нарыг хуульд заасан үндэслэл, журам нэрийн дор эрх зүйн байдлын хувьд ялгамжтай байдал үүсгэж байгаа нь төлөөллийн байгууллагаараа дамжуулан нутгийн удирдах ёсны үйл ажиллагаанд оролцох иргэдийн эрх, оролцоо ялгаатай түвшинд хүргэж байна.

Иймд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 1/3 хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэж заасан дээрх зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлж, хувь хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна. Монгол Улсын хэмжээнд боловсон хүчний тоо

эрс багасаж, төрийн бүх шатны байгууллага түүнчлэн төсвийн болон орон нутгийн өмчит компани, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах боловсон хүчний дутагдал үүсэж байгаа бөгөөд уг асуудлыг бодлогын түвшинд цогцоор нь шийдвэрлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Хөдөө орон нутаг болон алслагдсан сум, дүүрэгт ажиллаж, ажиллах боловсон хүчний дутагдлыг нөхөх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид харьяалагдаж буй ИТХ-ын төлөөлөгч нарын тодорхой хувийг төрийн захиргааны албан хаагч байхаар хуульд нэмэлт оруулж, Үндсэн хуульд заасан хуулийн өмнө тэгш, эрх тэгш байх зарчмын шаардлагыг хангах хууль зүй, нийгэм, эдийн засгийн чухал аль ач холбогдолтой юм.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Отгонбаяр гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Үг байгаа, тусдаа. Хууль санаачлагчид хариулж, нэмж тайлбар өгч болно. Зулпхар гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Энэ дээр хувь хэмжээтэй холбоотой асуулт байгаад байна. Суман дээр яах аргагүй хүний нөөц гэдэг талаасаа тухайн хувь хэмжээг тавиад, давхцах буюу нөгөө давхар дээлтэй байх боломжийг гаргаад өгчихсөн байгаа. Тэгвэл аймаг, нийслэл, дүүрэг дээр болохоороо тэр чинь ер нь ИТХ гэдэг тухайн нутаг дэвсгэрийнхээ парламент гэсэн үг шүү дээ тийм ээ, бодлого тодорхойлогч нь буюу төлөөллийн байгууллага. Тэгэхээр төлөөллийн байгууллага нь нөгөө төрийн албан хаагчдаараа ихэнх 50 хувь нь бүрдээд эхэлнэ гэхээр нөгөө асуудал шийдэх хувь чинь өөрөө юу гэдэг юм олонх нь ирснээрээ хүчин төгөлдөр болчихдог, ирц нь хүчин төгөлдөр болчихдог. Тэгээд ирсэн гишүүдийнхээ олонхоор нь шийдээд явчихаар асуудал шийдэгдчихдэг. Ингээд явахаар нөгөө иргэдийн төлөөллийн байгууллагын үндсэн чиг үүрэг маань хэр хангалттай биелүүлэгдэх вэ гэдэг энэ нэг ийм асуулт байна?

Яг энэ талаасаа харвал хувь хэмжээ дор хаяж 20 хувь буюу 20 хувиас хэтрэхгүй байж ядаж иргэдийн төлөөлөл үгээ хэлэх боломжтой буюу асуудал шийдэл шийдвэрлэхэд оролцох энэ боломжууд гарч ирэх ийм хувь хэмжээ харагдаж байгаа. Тэгэхээр яг зайлшгүй давхцаж орж ирж байгаа шалтгаан, нөгөө талаасаа шийдвэр гаргахад иргэдийн төлөөлөл нь шийдвэр гаргалтад ахиу хувьтай байх тэр боломж хоёроо харгалзаж үзэхгүй бол одоо юу гэдэг юм парламенттайгаа адилтгаад үзвэл парламентын гишүүдийн 50 хувь нь жишээлбэл Засгийн газрын төлөөлөл байж байх юм уу, сайдууд нь байж байх ч гэдэг юм уу иймэрхүү асуудал дээр шийдвэр гаргалт угаасаа л зөв гарч чадахад эргэлзээтэй болоод эхэлнэ шүү дээ. Тэгэхээр асуулт бол тэр. Яг яагаад 50 хувь юм бэ? Энэ хувь ер нь хамгийн багадаа гэх юм уу, эсвэл яг энэ шийдвэр гаргалтынхаа нөлөөллийг бодвол ер нь зохистой хувь нь хэд байж болох юм бэ хэрвээ зөвшөөрлөө гэхэд?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон, хууль санаачлагч Отгонбаяр гишүүн.

У.Отгонбаяр: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Одоогийн хуульд сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 1/3 хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэж заасан байгаа юм. Бид энэ заалт дээр нэмээд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн 50 хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч болно, байж болно гэдэг төсөл оруулж ирж байгаа юм. Тэгээд энэ тоо хэмжээ бол энэ хувь хэмжээ ажлын хэсгийн түвшинд, мөн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд энэ асуудлуудыг ярилцаад, ямар хувь хэмжээтэй байж болох бол энэ бол шийдэхэд нээлттэй байгаа. Эхний ээлжид ямар ч байсан 50 хувь гэж оруулж ирж байгаа юм. Ер нь зүгээр өнгөрсөн практикийг харж байхад энэ сумын түвшинд төрийн захиргааны алба хашчих энэ нөхцөлийг харахад үндсэндээ 30-аас 35 хувь хамгийн зохист харилцаа юм байна гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу, болсон уу? Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Энэ их чухал хуулийн санал орж ирж байна. Энэ бид бол ер нь заримдаа бодит байдалтайгаа нүүр тулаад, тэгээд нүүр тулсан учраас бид шийдвэр гаргах гарцаа байхгүй байдалтай байгаа гэдгээ мэдэж, шуурхай энийг хуулийн төсөл болгож оруулж ирж байгаад би хувьдаа бүрэн дэмжиж, нэг талаар талархаж байна.

Асуулт байна. Асуулт, та бүхний энэ хуулийн төслийн үндэслэл болсон тодорхой зарчмууд байгаа байх. Үзэл баримтлалтай холбоотой ч зүйл байж болох юм. Ер нь иргэдийн сонгох, сонгогдох эрхтэй холбоотой эрхийг баталгаажуулах чиглэлээр ямар жишээ нь нааштай үр дүн гарах юм бэ гэдэг нэг асуулт байна. Тухайн орон нутагт гэсэн үг шүү дээ.

2 дахь нь энэ хүй элгэний хувьд гэж байгаа юм. Би чинь 330 сумтай, 21 аймагтай, 9 дүүрэгтэй Улаанбаатар хот нь тийм ээ, энэ дээр нутгийн өөрийн удирдах байгууллага тэрний бүтцийн асуудал байна л даа. Тэгэхлээр нутгийн удирдлагын өөрийн удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр, эндээс гарч байгаа шийдвэрийг илүү шинэ шатад гаргах чиглэлээр ямар үр дүн, үр нөлөө үзүүлнэ гэж та бүхэн тооцож байгаа вэ гэсэн ийм асуулт байна? Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Отгонбаяр гишүүн, ажлын хэсгийн 3 номерын микрофон.

У.Отгонбаяр: Энэ маш өндөр ач холбогдолтой ийм зүйл, заалт нэмэгдэж байгаа гэж үзэж байгаа. Яагаад гэвэл нутгийн өөрөө удирдах байгууллагын 1 дүгээрт чадавх нэмэгдэнэ. Салбар салбарын төлөөллүүд, салбар салбарын экспертүүд энэ төрийн иргэдийн хуралд суух төлөөлөгч байх энэ боломж нэг талаараа бүрдэж байгаа юм. Энэ бүрдэж байна гэдэг бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавх, чанар чансаа мэдэгдэхүйц сайжрах ийм боломж бүрдэнэ гэж үзэж байгаа. 1 дүгээр асуултыг жоохон тодруулбал Зулпхар гишүүн.

Одоо бол нөхцөл байдал төрийн захиргааны алба хашиж байгаа иргэн бол төрийн албан хаагч бол сонгогдох, иргэдийн хуралд хэрвээ сонгогдохоор бол албан үүргээ төрийн захиргааныхаа албыг өгч байж иргэдийн сонгуульд оролцож байгаа. Тэгээд орон нутагт иргэдийн Хурлын Төлөөлөгч болсны ар дээр нөгөө төрийнхөө албыг, төрийн тэр дундаа төрийн захиргааныхаа албыг хаших боломж нь хязгаарлагдмал байгаад байгаа юм. Ганцхан сумд гэсэн заалт байгаа байхгүй юу. Одоо тийм учраас бид аймаг, нийслэл, дүүрэг гэж энийг хүрээг нь өргөжүүлж өгч байгаагаараа онцлогтой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ганц асуулт асууя. Нийтдээ аймаг, нийслэл, сум дүүрэгт улсын хэмжээнд 8031 иргэдийн Хурлын Төлөөлөгчид байна өнөөдөр. Аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчөөр 747, нийслэл 45, сумын иргэдийн хуралд 7239 хүн иргэдийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдон ажилладаг юм байна. Тэгэхээр энэ хуулийн төсөл хэрвээ батлагдвал нийт 8031 улсын хэмжээнд байгаа бүх шатны иргэдийн хурлын төлөөлөгчдийн 7239 нь одоо мөрдөгдөж байгаа хуулиар хүлээн зөвшөөрөгдчихсөн, төрийн захиргааны албан тушаал 1/3 буюу 30 хувь нь хийж болно гэсэн. Зөвхөн 790 орчим хүмүүсийн аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн, Отгонбаяр нарын гишүүдийн өргөн барьсан хуульд 50 хувь гэж яваа. Амгаланбаатар нарын гишүүдийн өргөн баригдсан байгаа хуульд 1/3 буюу 30 хувь гэж яваа. Ер нь эдгээр гишүүд юу яриад байна вэ гэхээр яах вэ орон нутгийн яг иргэдийн Хурлын Төлөөлөгчид энэ аймгийн иргэдийн хуралд хэрэгцээ шаардлага байна, дүүргийн иргэдийн хуралд хэрэгцээ шаардлага байна, тодорхой хэмжээнд төрийн захиргааны албан тушаалтан хийх тэр бололцоо боломжийг нь олгож өгөөч гэдэг ийм асуудлуудыг орон нутгийн иргэдийн хурлаас их тавьж байгаа. Тэр үүднээсээ энэ хэрэгцээ шаардлага байгааг үзэж, энэ нэр бүхий гишүүд энэ асуудлыг өргөн бариад явж байгаа гэдгийг хэлье.

Энэ тэгэхдээ урьд өмнө одоо огт цоо шинээр биш, бас өмнө нь байсан заалт, өмнө нь байсан заалт. Ингээд 17 оны өөрчлөлтөөр ингээд энийг хязгаарлаад, хориглоод ингэчихсэн байгаа. Тийм учраас цоо шинээр иргэдийн Хурлын Төлөөлөгчдийг төрийн захиргааны алба хааж болно гэдэг энэ хуулийн заалт биш. Өмнө нь байсан, одоо бас хэрэгжиж байгаа анхан шатдаа сумын иргэдийн хурлын төлөөлөгч байгааг өргөжүүлээд аймаг, дүүрэг, нийслэлд нь бий болго, нэгмөсөн бүх шатных нь иргэдийн хуралд нь тэр бололцоог нь олгочихъё гэсэн ийм үзэл баримтлалтай хуулийн төсөл гэж ингэж харж байгаа.

Тийм учраас энэ хуулийн төслийг, ер нь 50 хувь гэдэг өндөр гэж би хувьдаа харж байгаа. Тэгэхээр цаашлаад хэлэлцүүлгийн шатад ажлын хэсэг дээр энэ хувийг сая Уянгахишиг гишүүнтэй яриад байгаатай санал нэг байна. Бууруулах, 50 хувь нь арай өндөр байна. Тийм учраас тодорхой хэмжээнд 20-оос юм уу, 30 хувь энэ хүртэл байх хэмжээнд байх бололцоо боломжийг нь ажлын хэсэг дээрээ ярьж байгаад, ингээд өөрчилчих бололцоотой юм байна гэсэн ийм байдлаар асуудлыг ярьж байгаа. Ер нь хэдийгээр өнөөдөр хуульдаа ер нь яг төрийн захиргааны албан тушаалтан, төлөөлөгч хүн төрийн захиргааны албан тушаалтан хийж байгаа хүн байна уу Отгонбаяр даргаа? Мөн төлөөлөгчдийн хэдэн хувь нь төрийн өмчит болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга хийж байна вэ? Мөн өнөөдөр төлөөлөгчдийн хэдэн хувь нь төрийн үйлчилгээний байгууллагад эмнэлэг, сургууль, цэцэрлэгт удирдах юм уу, гүйцэтгэх албан тушаал хийж байгаа ийм тоо баримт, судалгаанууд байдаг юм уу? Энэ нь өнөөдөр яг мөрдөгдөж байгаа хуулиараа аль хууль дээр зөрчилтэй зүйл, заалтууд болоод байна вэ гэдэг юм, энийг нэг та бүхэн тодруулж өгөөч. Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

У.Отгонбаяр: Өнөөдрийн саяын 8031 улсын хэмжээнд байгаа энэ төлөөлөгчдөөс төрийн захиргааны албыг 110 хүн хашиж байна. Төрийн тусгайд 1, төрийн үйлчилгээнд 1576, улс төрийн 1862 гэсэн ийм статистик мэдээ байгаа. Үүнээс мөн 329 төрийн өмчит болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт алба хашиж байна. Энд 329-өөс удирдах албан тушаалд 184, бусад албан тушаалд 146 хүн төлөөлөгч төрийн албанд ажил, албан тушаал хашиж байгаа.

Сандаг-Очир даргын сая эхэнд нь тодруулж асуудаг Төрийн албаны тухай хуулийн хэд хэдэн зүйл, заалттай зөрчилдөж байгаа. Тэгээд энийг хэрвээ энэ Нэгжийн тухай хуулийн асуудал Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэх асуудал нь шийдэгдээд, хэрвээ батлагдаад явбал ирэх жилийн 2026 оны 6 сарын 1-нээс хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм. Тийм учраас тэр хүртэл Төрийн албаны тухай хуульд харшилж байгаа 4 заалт байгаа юм. Энэ 4 заалтыг энэнтэй уялдуулж, засаж залруулж, засаж янзлах ажлыг би өөрөө мөн яг энэ хуулийг өргөн барьсан 8 гишүүний хамтаар Улсын Их Хуралд хэлэлцүүлээд, нэмэлт, өөрчлөлт оруулаад явна гэсэн ийм бодолтой байгаа.

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримттай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Идэрбат гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн үгээ, Зулпхар гишүүн үгээ хэлье.

С.Зулпхар: Би энэ хуулийн төслийг дэмжиж байна. Угаасаа бид ингээд түрүүн ч хэлсэн, бодит байдалтайгаа бид нүүр тулах ёстой. Сумдын хүн ам бол зарим сумдад маш цөөрч байгаа дотоод шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор. 1500 хүртэлх хүн амтай жижиг сум байна, 1500-аас 2500 хүн амтай жижгэвтэр сум байна, тэгээд 2500-аас 3500 хүн амтай дундавтар сум байна. Тэгээд энэ сумд чинь өөрөө нөгөө хүй элгэний зохион байгуулалттай, жишээ нь хүмүүс нь нийгэм, эдийн засаг, соёлын тийм зохион байгуулалтад ордог ийм зүйл юм. Тэгээд тэнд тэртээ тэргүй жишээ нь саяын бидний хэлсэн нутгийн өөрөө удирдах байгууллага нь чадавх нь сайн байхын тулд тодорхой жишээ нь иргэдийн сонгох эрхийг нээж өгөхгүй бол энэтэй холбоотой маш их өнгөрсөн хугацаанд асуудал дагалдсан.

Бид заримдаа сумын ИТХ бол дан ганц тухайн сумдын тодорхой иргэдийн төлөөлөл болчихоод, шийдвэр гаргахад тэр хүмүүсийн мэдлэг, чадвар туршлагаас шалтгаалсан хүндрэлүүд сорилтууд учирч байна гэдгийг бол байнга ярьсан. Энийг манай орон нутгаас сонгогдсон гишүүд маань сайн мэдэж байгаа, энийг байнга ярьдаг байсан. Угаасаа урьд нь бас манайд угаасаа тогтолцоо нь байсан юм. Төрийн албан хаагчид төрийн захиргааны буюу төрийн жинхэнэ албан хаагчид ИТХ болж болдог ийм зохицуулалт байсан. Гэхдээ бид яах вэ мэдээж хэрэг тэр нь хэт их улс төржилт яваад, асуудал үүсээд байсан учраас захиргааг улс төрөөс салгах зорилгоор ийм шийдвэр гаргасан юм байгаа юм.

Гэхдээ бид ингээд салгаж байна гээд ялгавартай авч үзээгүйгээс болоод сумын түвшинд, дүүргийн түвшинд ийм буцаад асуудлууд гарсан. Хурал дээр өөрөөр хэлбэл шийдвэр гаргахаар зэрэг шийдвэр гаргалттай холбоотой мэргэшсэн ийм чадавх суларсан байдал бий болсон гээд. Энэ үүднээс нь аваад үзвэл Отгонбаяр нарын санаачилсан энэ хуулийн төсөл бол сумын түвшинд ИТХ-ын чадавхыг бэхжүүлэх талаасаа их чухал. Цаашлаад дүүргийн түвшин, дүүрэг ч гэсэн хүй элэгний л зохион байгуулалттай, энд чадавхыг бичүүлэх талаасаа их чухал гэдгийг тэмдэглэмээр байна. Нөгөө талаар сая бол Сандаг-Очир гишүүн ч гэсэн тэмдэглэж байна, манай Уянгахишиг гишүүн ч гэсэн тэмдэглэж байна. Бид ингээд хувь хэмжээтэй холбоотой зүйлийг ялгавартай бодох ёстой байх. Сумын түвшинд хэд байвал зохимжтой юм гэдгийг ахиж судалгаан дээр суурилсан байдлаар тооцох хэрэгтэй. Дүүргийн түвшинд ямар байх юм, аймгийн түвшинд ямар байх юм гээд ингээд үзсэн нь зөв байх гэж бодож байна.

Үндсэндээ энэ бол өнөөдөр байгаа бидний өмнө тулгамдсан зарим нэг сорилтын зайлшгүй хийх ёстой шийдэл нь болчихсон ийм асуудал шүү гэж байгаа юм. Тэгэхээр би хувьдаа дэмжиж байна. Бид энийг ахиад явц, хэлэлцэх явцад нь нарийвчлан судалгаан дээр суурилсан байдлаар хэлэлцээд, энийг дэмжих нь зүйтэй байх гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа та бүхэнд.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Хуулийн төслийг үндсэндээ дэмжиж байгаа. Энэ ер нь энэ хуульд өөрчлөлт орвол ийм хуулийн төсөл өргөн барих нь зүйтэй гэж үздэг байсан. Харин манай Отгонбаяр болон гишүүд маань ингээд оруулаад ирж. Тийм болохоор ямар ч л байсан дэмжиж байгаа. Ер нь орон нутгийн хүрээнд иргэдийн хурлыг чадавхжуулах, иргэдийн хурлыг сайжруулах хүрээнд боловсон хүчнийг бид зайлшгүй нэмэгдүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах ийм зүйл зайлшгүй байгаа. Тэгээд энэ хүрээндээ төрийн албан хаагч төрийнхөө үйл хэрэгт үнэхээр зүтгээд, мэргэшээд, тэгээд дараа нь төр барих, өөрөөр хэлбэл орон нутгийн удирдлага руу орж ажиллах гэсэн ийм шат дарааллаар ер нь явдаг шүү дээ. Тэр утгаараа тухайн орон нутгийн удирдах байгууллага нь улам чангарч байдаг, улам сайжирч байдаг ийм зүй тогтол байгаа.

Тэгээд энэтэй уялдуулаад төрийн албанаас магадгүй юуны нутгийн удирдлага энэ байгууллага руу ороод, тэндээсээ цаашаага яг нөгөө мэргэшсэн байдлаараа Засгийнхаа юунд бүрэлдэхүүнд ороод, өөрөөр хэлбэл төрийн албанд ороод ажиллах ийм боломж бололцоо 1 дүгээрт гардаг. 2 дугаарт энэ нь өөрөө засаг захиргааны байгууллагаас гарч байгаа шийдвэрт нөлөөлдөг, шийдвэр нь улам чанарждаг ч байдаг юм уу, мэргэшсэн байдаг ч байдаг юм уу энэ тал руугаа харахад энэ өнцгөөс харахад зөв зүйтэй харагдаад байгаа.

Зүгээр би дутуу ороод ирж дээ л гэж бодож байна. Цаашдаа та хэд маань анхаараад, дахин оруулж ирэх нь зүйтэй болов уу. Төрийн албанаас орон нутгийн сонгуульд орохдоо төрийнхөө албанаас чөлөөлөгдөж байгаа. Тэгээд буцаад төрийн албандаа орох гэхээр тэр нь ямар нэгэн байдлаар орох боломж, бололцоогүй хаагдчихдаг. Тэгээд орон тоо байхгүй ч гэдэг юм уу, янз янзын нөхцөл байдал бий болдог. Тэгэхээр энэ нь өөрөө баталгааждаг, ямар нэгэн байдлаар тэр хуулийн заалтаар баталгааждаг, сонгуульд орлоо, өрсөлдлөө, хэрвээ орж чадаагүй бол буцаад төрийн албандаа очоод ингээд ажлаа хийдэг ийм нөхцөл байдлыг хэрвээ бид юундаа хуульдаа, өөрөөр хэлбэл нөгөө Сонгуулийн тухай хуульдаа хэрвээ орчихвол илүү мэргэшсэн хүмүүс энэ төрийн, өөрөөр хэлбэл нутгийн удирдах байгууллагад орох ийм боломж, бололцоо нээгдэх ёстой юм.

Энэ дээр нь бид тэр хуульдаа, өөрөөр хэлбэл Сонгуулийн тухай хуульдаа нэг оруулаад ингээд цогцоороо явсан бол арай дээр гэж бодож байсан. Тэрийг та бүхэн маань анхаарч, цаашаага ажиллана биз ээ. Ямар ч байсан хууль маань хуулийг бол дэмжиж байгаа. Бас нэг хугацаа, тэр тоон дээр нэлээн бодолцох асуудал байгаа байх. Сая эндээс хэн гишүүн маань хэллээ. Өөрөөр хэлбэл нийслэл дээр ямар байж болох юм, аймаг дээр ямар байж болох юм, тэгээд магадгүй боловсон хүчний дутагдалтай хязгаар нутаг руу тэр болгон төрийн албан хаагчид очиж ажиллах боломж, бололцоо өнөөдөр ч заримдаа хаагдмал байж байна. Сум, орон нутаг дээр боловсон хүчний хүртээмж багатай байж байна. Ийм нөхцөл байдлыг нь бодоод, орон нутаг дээр, сум дээр ямар байх юм, сум, аймаг дээр ямар байх юм, нийслэл ямар байх юм гэдгийг нь тодорхой ажлын хэсэг дээр дүнг нь олоод тааруулаад

ингээд ажлын хэсэг саналаа оруулаад явах нь зүйтэй байх гэсэн ийм л саналтай байж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Дэмжих болсон үндсэн шалтгаан юу вэ гэхээр орон нутаг дахь төрийн албаны чадвар, чансаа муудсан юм. Өмнө нь байсан заалт яагаад алга болсон юм бэ гэвэл аймаг, сум, дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид хурлын танхимдаа орохоороо Засаг даргыгаа хяналт тавьдаг, ажлыг нь дүгнэдэг. Тамгын газарт орохоороо Засаг даргынхаа удирдлага дор орчихдог. Нөгөө захирах, захирагдах ёсны асуудал нь өөрөө нөхцөл байдал нь болохгүй байна гэдэг, дээр нь улс төрийн намыг энэ төрийн албанаас ангид байлгая гэдэг ийм зүйл ярьж байгаад тухайн үед ингээд энэ заалтыг байхгүй болгочихсон юм. Энийгээ дагаад өнгөрсөн хугацаанд төрийн албан хаагчийн чадамж муудчихсан.

Дээр нь энэ хурлын төлөөлөгчдөд нэр дэвших боломжтой улсууд бас байхгүй болсон. Яагаад гэхээр энэ чинь өөрөө төрийн алба юу, хурлын төлөөлөгч чинь цалин авдаггүй юм. Тэгэхээрээ нөгөө нэр дэвшихээсээ илүүтэйгээр бараг зүгээр төрийн захиргааны ажлаа хийгээд явж байх нь зөв гэдэг байр суурийг ингээд аваад үлдчихдэг. Тэгээд энэ дээр нэг их тийм давхар хашаад, түрүүний миний хэлсэн шалтгаан л байгаа болохоос бусдаар нэг их айхтар зөрчил үүсээд байхгүй юм байна гэж хардаг юм.

23 оны 10 сард 24 онд болох Орон нутгийн сонгуулийн хуулийг өмнөх парламент баталж чадаагүй юм. Үндсэндээ хуучин хуулиар явж байгаа юм. Өнгөрсөн 24 оны Орон нутгийн сонгуулийн хуулиар сумд болон аймагт давхар нэр дэвшээд, хоёуланд нь ялалт байгуулаад, гарсан хойноо нэгийг нь сонгоод, давхар байж болохгүй болчхож байгаа юм. Тэгэхээрээ нэгийг нь сонгоод явсан, энэтэй үүдээд сая энэ өнгөрдөг зун 6 сард нөхөн сонгуулиуд нэлээн явагдлаа. Энд төрд нэлээдгүй зардал мөнгөний зүйл болсон. Тэгэхээр энэ Төрийн албаны хууль, энэ Нэгжийн хууль, Сонгуулийн тухай хууль гээд энэ хуулиудыг энэ ажлын хэсэг байгуулагдаад явах байх цаашдаа. Энэ дээрээ нэлээн уялдаа хангаж, харилцан ийм юм яахгүй бол буцаад энэ нь өөрөө төрд их хохирол учирдаг нэг ийм зүйл болоод байгаа юм.

Дараагийн нэг чухал асуудал одоо өвөл болж байна. Энэ өвөл удахгүй ингээд ес эхэлнэ. Энэ Төрийн хэмнэлтийн хууль гэдэг зүйлийг ер нь бид нэг Засгийн газарт чиглэл өгөөд, эргэж харахгүй бол болохоо байсан юм шиг байгаа юм. Тухайн цаг үедээ хүндтэй үүргээ гүйцэтгэчихсэн гэж харж байгаа. Одоо яг энэ сумд, хөдөө орон нутагт, ялангуяа энэ өвлийн улиралд, энэ хаврын улиралд энэ Хэмнэлтийн хуулиар хамаг юмыг нь хаагаад хаячихсан байдаг. Гэтэл тэнд бензин тосны ч зардалгүй ингээд, магадгүй өвөл хүндрээд, хавар хүндэрвэл яах вэ гэдэг асуудал эндээс урган гарч ирнэ.

Нийслэл, дүүрэг энэ ойр тойрондоо болоод байдаг юм шиг байгаа юм. Гол нь тэр орон нутагтаа бид энэ Хэмнэлтийн хуулиа нэг ялгавартай хандахгүй бол болохгүй юм болов уу гэсэн ийм зүйл дээр дараа дараадаа энэ бас, уул нь энэ хуулиа дагуулаад эсхүл Засгийн газарт манай Байнгын хорооноос чиглэл өгдөг юм уу нэг тийм статистик гаргаж ирж оруулж ирэхгүй бол одоо цаг хугацаа яваад байгаа. Энэ талаар яг энэ хуультай холбоотой орон нутгаас аягүй их саналууд ирж байгаа

байхгүй юу. Энэ төрийн алба, энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа хуультай холбоотой. Тэгэхээр энэ хуулийг бид цаг алдахгүй батлаад явуулах ёстой гэсэн байр суурийг Засгийн газарт өгөх нь зөв байх гэсэн бодолтой байж байна. Баярлалаа, дэмжиж байна.

Ц.Сандаг-Очир: Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тийм, энэ хуулийг дэмжиж байгаа. Тэгээд энэ хууль ингээд батлагдаад явах нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, төрийн үйл хэрэгт ч гэсэн хэрэгтэй гэж ингэж би харж байгаа юм. Гэхдээ энэ бол нөгөө сая гишүүд нэлээн ярьж байна шүү дээ хуучин бол байсан юм гэж. Тэгэхээр би харин зүгээр нэг зүйлийг бодоод байна л даа. Яг Нутаг дэвсгэрийн нэгжийн хууль дээрээ ингээд өөрчлөлт оруулчихдаг, Төрийн албаны хууль дээр чинь бас нэг тийм, зөрчилдөөд байдаг. Тэгээд яг маргаан үүсэхэд, маргаан үүсэхэд энэ хүн ингээд төрийн албанд орж ажиллах болно, нөгөө 30 хувь байдаггүй тэр квотдоо багтчихсан юм гээд ингээд үзэхээр шүүх бол Төрийн албаны хуулийг нь бараг барьж үзчих гээд байдаг. Тэгээд тэрийг бол хууль зөрчсөн байна гэж ингэж үзчих гээд байдаг ийм практик энэ хууль хэрэгжиж байх үед байсан юм.

Тэгэхээр хэдүүлээ нэгэнт энэ хуулийг ингээд бариад авсан юм чинь тэр Төрийн албаны хууль дээрээ ч гэсэн давхар өөрчлөлт хийгээд, тухайн иргэдийн Хурлын Төлөөлөгч төрийн захиргааны албан дээр ямар нэгэн байдлаар очлоо гэхэд эргээд шүүхэд хандлаа гэхэд Төрийн албаны хуулиараа уначихдаггүй байх хэмжээнд би бол байх ёстой болов уу гэсэн нэг ийм санал байна.

2 дугаарт яг одоо энэ хэлэлцэж байгаа асуудалтай биш, Байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоотой асуудал дээр нэг горимын санал байна. Ялангуяа энэ Евразитай холбоотой асуудал дээр намын бүлгүүд ч санал, дүгнэлтээ гаргасан. Өчигдөр Монгол Ардын намын бүлэг ч ярилцсан. Евразийн энэ хэлэлцээр батлагдсанаар Монголын хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн бас энэ 10 гаруй тэрбум доллар эргэлдэж байгаа энэ зах зээл рүү гарах бололцоо байна гэж үзэж байгаа юм. Нөгөө нэг бидний яриад байдаг арьс шир, мах, дайвар бүтээгдэхүүн гээд ингээд хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн голчлон байгаа. Энэ нь өөрөө манай хөдөө аж ахуйн салбарт бол өөрөө маш том дэм болно гэж ингэж харж байгаа юм.

Тийм учраас сая Байнгын хорооны хэлэлцэх асуудлын эхэнд байгаад, ирцэд орсон гишүүд танхимд хүрэлцэн ирж, ирээгүйгээс болоод ингээд харамсалтай нь унасан байна. Тэгэхээр энэ дээр, энэ бол зүгээр нэг хэлэлцэх асуудлыг эсэхийг ингээд нэг шийдчих асуудал бас биш. Цаанаа эдийн засгийн, геополитикийн олон асуудлууд байгаа болов уу. Тэгэхээр горимын санал бол энэ асуудлыг дахин оруулж ирэх бололцоо байна уу, хууль, эрх зүйн хувьд гэдэг ийм л зүйлийг би хэлье гэж ингэж бодож байна. Тэгээд энэ дээр Байнгын хорооны зүгээс нэг хариулт өгөөд, эргээд дахиад Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлөөр хэлэлцэх үү яах вэ, энийг өөр бас дахиад нэг нухацтайнхан үзвэл яасан юм бэ гэсэн ийм горимын санал байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлж дууслаа. Идэрбат гишүүний ярьсантай холбогдуулаад саяын Евразийн гэрээг соёрхон батлах тухай энэ хуулийн төслийг сая 2 санал хураагаад, эхнийх дээр нь унаад, Баярбаатар гишүүн горимын санал гаргаад дэмжигдсэнгүй. Ер нь гишүүд өөрийнхөө хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж өөрийн байр

сууриар саналаа өгөх эрхтэй. Тэгээд ер нь зарим гишүүд улс төрийн хувьд дэмжихгүй байгаа гэдэг байр сууриа илэрхийлж байгаа учраас гишүүдийг шахах ямар нэг бололцоо, боломж байхгүй. Зүгээр дахиж энийг Даргын дэргэдэх зөвлөл дээр ирэх долоо хоногт хэлэлцэх эсэхийг дахиж оруулж ирж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулбал ахиж хэлэлцэх тэр нэг гарц гаргалгаа байхыг үгүйсгэхгүй. Тэрнээс өнөөдрийн Байнгын хорооны хурлаар дэмжигдээгүй ингээд явж байгаа нь энэ намрын чуулганаар хэлэлцэх бололцоогүй болон боломжгүй байдлыг үүсгэж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд дахиж Даргын дэргэдэх зөвлөл дээр 5 дахь өдөр ярилцахыг үгүйсгэхгүй. Үнэхээр ач холбогдолтой, шаардлагатай гэвэл ахиад ирэх долоо хоногийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж ирэхийг үгүйсгэхгүй гэдгээ хэлье. Өнөөдөр ахиж хураалгах тийм, санал хураалт явуулах бололцоогүй болсон. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууссан. Санал хураалтдаа бэлдье. Бүгдээрээ санал хураалтдаа бэлдье. Ирц хүрэхээр байна уу?

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураа. Санал хураалт. 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар санал дэмжигдлээ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Хэлэлцсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганд хэн танилцуулах вэ? Зулпхар гишүүн танилцуулчих уу? Тэгье. Санал хураалт байгаа шүү Болормаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Зулпхар гишүүн нэгдсэн чуулганд танилцуулна. Ингээд 2 дахь асуудлыг хэлэлцэж дууслаа.

16.22 цаг

Гурав.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын Улсын Их Хурлын 2 гишүүн 2025 оны 6 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Асуулттай гишүүн байхгүй байна. Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Улсын Их Хурлын гишүүн Уянга, зарчмын зөрүүтэй саналын томъёолол 1 дээр. Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн

долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна.” Санал, энэ зарчмын зөрүүтэй тайлбарлах уу? Тэгье. Ажлын хэсгийн 3 номерын микрофон, хууль санаачлагч Уянга гишүүн.

Б.Уянга: Энэ саналын томьёоллыг яагаад оруулж ирж байгаа вэ гэвэл 6 сарын 25-нд Засгийн газрын хуралдаанаар яг энэ хуулийн төслийг хэлэлцсэн тэмдэглэл албан ёсоор ирсэн байгаа. Тэгээд энэ тэмдэглэл дээр бол ерөнхийдөө нийтээр тэмдэглэх баярын тэмдэглэлт өдрүүдийн тухайд Монгол үндэстнийхээ уламжлалыг хүндэтгээд, яг энэ 2 гол баяраа цагаан сар болон наадам энэ 2 баяртай холбогдуулаад хэрвээ амралтын өдөр дамнавал тэр зохицуулалтыг нь хуульд буцаж тусгая гэсэн энэ санал орж ирсэн. Тэгээд яг энэ Засгийн газрын саналаар томьёолоод оруулж ирж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Зөвхөн үндэсний их баяр наадам, цагаан сар тийм үү? Тэгээд тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараа долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлнэ. Манайх 16. Санал хураалт гишүүдээ, санал хураалтад бэлдье. Санал хураалтдаа бэлдье гишүүдээ. Санал хураалтдаа бэлдье гишүүдээ. Санал хураалт явуулъя, зарчмын зөрүүтэй, хууль санаачлагч Уянга гишүүний зарчмын зөрүүтэй гаргасан, хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 2 наадам, цагаан сар. Санал хураалт. 41 хувиар санал дэмжигдсэнгүй. Уянга гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдээгүй учраас анх өргөн барьсан хуулийн төсөл нь дэмжигдэж байна гэсэн үг. Анх өргөн барьсан хуулийн төсөл нь болохоор бүх баяруудыг хамаарахаар, бүх баярын өдрүүд амралтын өдөр таарвал дараагийн долоо хоногт шилжүүлнэ гэсэн энэ хуулийн төсөл нь дэмжигдэж байна гэсэн үг шүү гишүүдээ.

Уянга гишүүний зарчмын зөрүүтэй санал дэмжигдээгүйтэй холбогдуулан төслийн 1 дүгээр зүйл дээр ахиад зарчмын зөрүүтэй, Д.Энхтүвшин гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол байна. 1, та бүхэнд зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “давхацсан бол” гэсний дараа “долоо хоног бүрийн амралтын” гэж нэмж, төслийн тайлбарыг хасах. Ингэхээр ямар болж уншигдаж байна вэ? Давхацсан бол гэсний дараа долоо хоног бүрийн, саяын Энхтүвшин гишүүний зарчмын зөрүүтэй саналыг ойлгосон уу гишүүдээ? Ахиад уншаадахъя тэгэх үү? Харин тийм. Би нэгтгээд уншаадахъя. Шигтгэсэн нь байна уу? Ажлын албаныхан алив, шигтгэснийг нь уншихвал гишүүдэд ойлгомжтой болох гээд байна. Хэн гишүүний, Энхтүвшин гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг шигтгэсэн хэлбэрээр нь би уншаадахъя. Нийтээр тэмдэглэх баярын өдөр нь долоо хоног бүрийн амралтын өдөртэй давхацсан бол Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 6.4 дэх хэсэгт заасныг баримтална. Энэ зөв үү? Энэ өөр байна шүү дээ, энэ өөр байна.

Нийтээр тэмдэглэх баярын өдөр долоо хоног бүрийн амралтын өдөртэй давхацсан бол давхацсан өдрийг дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ. Одоо ингэж уншиж байна. Энэ Энхтүвшин гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал. Түрүүний Уянгаа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй. Тэгвэл Уянга гишүүнийх чинь зөвхөн баяр Үндэсний их баяр наадам, цагаан сар байсан. Одоо бол бүх баярууд ороод ирж байна гэсэн үг. Нийтээр тэмдэглэх баярын өдөр долоо хоног бүрийн амралтын өдөртэй давхацсан бол давхацсан өдрийг дараагийн

өдрийн, дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ. Бүх. Санал хураалтдаа бэлдье гишүүдээ.

Энхтүвшин гишүүний гаргасан хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр гаргасан зарчмын зөрүүтэй санал, би дахиж уншиж өгье. 6.4.Нийтээр тэмдэглэх баярын өдөр долоо хоног бүрийн амралтын өдөртэй давхацсан бол давхацсан өдрийг дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ. Тэгээд төслийн тайлбарыг хасах гэж байгаа. Санал хураалт. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 52,9 хувиар санал дэмжигдлээ. Энхтүвшин гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдлээ.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байна. Ажлын хэсгээс бэлдсэн. 2 дугаар зүйл дээр үү? 2 дугаар зүйл дээр. Номин гишүүн.

Ч.Номин: Би энэ хуулийн талаар нэг тодорхой ойлголт өгөх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Мэдээж бид иргэдээ амрааж, дээрээс нь иргэддээ чиглэсэн шийдвэр гаргах нь зүйтэй. Энийг дэмжиж байгаа.

Гэхдээ бид бас энэ шийдвэрийг гаргахдаа нөгөө талдаа бизнес эрхлэгч нараа бодох хэрэгтэй. Бизнес эрхлэгч нарт маань дарамт багатай байж цаашдаа цалин мөнгөө нэмэгдүүлэхэд илүү ач холбогдолтой. Би та бүхэнд өнөөдрийн яг энэ хуультай холбогдолтой судалгаа хэлье. Монгол Улс нийтдээ 248-аас 250 хоног хүмүүсээ ажиллуулдаг. Үүнээс яг өнөөдрийн байдлаар энэ хуулийг энэ чигээр нь баталбал жилд дунджаар 2-оос 3, бүүр цаашлаад 5 хоног хүртэл амралтын өдөр нэмэгдэх гэж байгаа гэсэн үг. Мэдээж энэ нөгөө нийтээр амрах 16 хоногийг нэмэгдүүлж байгаа биш, гэхдээ нөгөө яг амралтын өдөр лүү шилжиж байгаатай, амралтын өдөр нь ажлын өдөр лүү шилжиж байгаатай холбогдуулаад ажил олгогчид талдаа бол 5 хүртэл хоногоор ажлын өдөр нэмэгдэж байна гэсэн, амралтын өдөр нэмэгдэж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ өдрүүдэд нэмэгдсэнтэй уялдуулаад энэ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид чинь цалин мөнгөө 2-оос 3 дахин нэмэгдүүлж төлөх шаардлага үүснэ. Нөгөө талдаа яах вэ бүүр хаачихдаг юм байлаа гэж бодоход тухайн өдрүүдэд түрээсийн орлого, түрээс төлж байгаа хүмүүс юм уу, зардал гаргаж байгаа хүмүүс энэ зардал нь гардгаараа л гарна. Том аж ахуйн нэгж бол мэдээж энийг шингээгээд явчихна, ямар ч асуудалгүй. Гэтэл жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид дээр энэ цэвэр дарамт болж орж ирдэг.

Нөгөө талдаа бид нийтээр ингээд 2-оос 3 хоногийг ажлын өдрийг амралтын үйлдвэр болгоод шилжүүлж байгаатай уялдуулаад Монгол Улсын хэмжээнд бүтээмж нэг хувиар бууна. Энд бид чинь тийм бүтээмжтэй улсын тоонд ордоггүй. Тэгэхээр энэ бүтээмж буурч байгаа гэдгийг бид бас тооцож үзэх хэрэгтэй. Уг нь сая Уянгын оруулж ирсэн зарчмын зөрүүтэй санал аягүй зөв байсан байхгүй юу. Юу вэ гэхээр цагаан сар, наадам гэсэн уламжлалаа шингээсэн ийм томоохон баярууд буюу олон хоногтой баяруудаараа хязгаарлаж өгч чадвал иргэдээ ч бодсон шийдвэр, нөгөө талдаа хувийн хэвшил, бизнесээ ч бодсон ийм шийдвэр байсан. Гэтэл бид энэ бас уначихлаа. Тэгэхээр уг нь аль, аль талаа бодож бид шийдвэрээ гаргаж явбал цаашдаа хэрэгтэй.

Тэгээд бид чинь дэлхийд өрсөлдөж байгаа улс бүтээмжийн нэг хувиар бууралт бий болно гэдэг чинь эргээд бидэнд эдийн засагт нөлөөлнө. Дахиад үүнтэй чинь зэрэгцээд хил гааль хаагдана, эргээд нөгөө экспорт буурна гээд ийм асуудлууд байгаа гэдгийг та бүхэн маань тооцох хэрэгтэй. Энэ чинь бизнес эрхэлж байгаа жижиг, дунд эрхэлж байгаа хүмүүст эргээд ачаалал болж ирж байгаа юм шүү гэдгийг ойлгож, энэ шийдвэрүүд гарах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Уянга гишүүний төслийн 2 дугаар зүйл дээр Төслийн 2 дугаар зүйлийг тус тус хасах гэсэн байна. Санал хураалт. Санал хураалтдаа бэлдье гишүүдээ. Дагаж мөрдөх хугацааг нь зүгээр ердийн горимоор гэж байгаа юм. Тийм, ердийн горимоор. Баталсан өдрөөс дагаж мөрдөнө гээд оруулаад ирчихсэн байсан. Ердийн горимоороо. Төслийн 2 дугаар зүйлийг тус тус хасах. Санал хураалт. 17-гоос 11 хүн дэмжиж, 64,7 хувиар санал дэмжигдлээ.

Дагасан хууль байгаа билүү? Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Байхгүй байна. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуух асуулт, санал, зарчмын зөрүүтэй санал алга байна.

2 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй саналтай хүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол байна. Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх. Хөдөлмөрийн тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг саяын уншсан томьёоллоор дахин уншъя. Төслийн 2 дугаар зүйлийн баталсан гэснийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон гэж өөрчлөх. Санал хураалт. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 9 гишүүн дэмжиж, 52,9 хувиар санал дэмжигдлээ.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн гишүүн танилцуулчих уу, чуулганд танилцуулчих уу? Хэрлэн гишүүн танилцуулна. 3 дахь асуудал хэлэлцэж дууслаа.

16.41 цаг

Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

4 дэх асуудал. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд санал, дүгнэлтээ танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргахаар гэж заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан гишүүдэд тараасан байгаа.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулт, үг хэлэх гишүүн байна уу? Тогтоолын төслийг тараасан байгаа, унших шаардлагатай юу, шаардлагагүй юу? Бүгдэд нь тараачихсан байгаа. Тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүн байна уу? Үг үг хэлэх, асуулт, үгээ нэгтгээд явчихъя, хамтатгаад явчихъя. Тэгвэл уншиж танилцуулъя. Энэ ямар учраас, ямар тогтоол агуулгаар ороод ирэв гэдгийг. Үгүй ээ, тогтоолын төслөө биш, танилцуулгаа уншаадахъя болох уу, шаардлагагүй юу? Тэгье, танилцуулгаа уншихгүй бол болохгүй байх.

Засгийн газарт өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар. Монгол Улсын Их Хурлын даргын 24 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд санал, дүгнэлтээ танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргахаар гэж заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан боловсруулан танилцуулж байна.

Уг тогтоолын төсөлд төрийн байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах, иргэнд очих төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгох хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах, зарим арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газарт чиглэл болгохоор тусгалаа.

Тухайлбал, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулахад төрийн хяналт шалгалтын тогтолцоог оновчтой болгох, үүнтэй холбогдуулан бизнес эрхлэх үйл ажиллагааг дэмжих, зөвшөөрөл олгох процессыг хөнгөвчлөх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх шаардлагатай байгаа тул дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 26 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгохоор төсөлд тусгалаа.

Иргэн, аж ахуйн нэгжид зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн хяналтын хүрээг оновчилж, хүнс, эрүүл ахуй, эм, эмчилгээний чанар, уул уурхай, газрын тос, байгаль

орчин, дэд бүтэц, боловсрол зэрэг нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хөндөгдөж, эсхүл зөрчигдөх эрсдэлтэй үйл ажиллагаанд хяналт тавих төрийн хяналт шалгалтын зарчмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг;

2-т аж ахуй эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах, өрсөлдөөнт чөлөөт зах зээлийн эдийн засаг өргөжих, хөгжих боломжийг бэхжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, өмчийн халдашгүй байдал, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах хүрээнд Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг.

Түүнчлэн төрийн байгуулалтын бүтээмжийг дээшлүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах, иргэнд очих төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгох хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгахаар тусгалаа. Нэгд, эдийн засгийн салбарууд дахь аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоо, мэргэжилтнүүдийн нэгдсэн дуу хоолойг сонсох, салбарын мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, төрийн зарим чиг үүргийг мэргэшсэн байгууллагад шилжүүлэх хүрээнд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шаардлагатай бол уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Хүн төвтэй төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай, хүртээмжтэй, цахим хэлбэрээр хүргэхийг үндсэн хэлбэр болгож, их өгөгдөлд суурилсан бодлого, шийдвэр гаргалтыг төлөвшүүлэх. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх дарамтыг багасгах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор зөвшөөрөл олголтын процессыг хялбарчлан, ил тод, нээлттэй зарчмыг баримтлан цахим хэлбэрт шилжүүлэн хяналтыг сайжруулах, мөн эрсдэл багатай, нэг удаагийн шинжтэй үйл ажиллагааг зөвшөөрөл шаардахгүйгээр мэдэгдэл хүргүүлээд эрхлэх боломжийг бүрдүүлэх.

3.Бизнесийн үйл ажиллагааг төрийн хяналт шалгалт нэрийдлээр хясан боогдуулдаг байдлыг таслан зогсоож, хяналтын төрлийг оновчлох, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах хүрээнд салбарын хяналтыг улсын төсөвт ачаалал үүсгэхгүйгээр, төрийн албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэхгүйгээр Засгийн газар дахь хяналтын чиг үүрэгт нэгтгэж, төвлөрсөн удирдлагаар хангах арга хэмжээг 26 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх зэрэг болно. Ингэснээр хүн, хуулийн этгээдийн бизнес эрхлэх таатай орчныг сайжруулах бөгөөд дараах үр дүнд хүрнэ гэж үзлээ.

1-д, аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх боломж бүрдэнэ. 2-т, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжнө. 3.Төрийн үйлчилгээг цахимжуулан оновчилж, бүтээмж нэмэгдэнэ. 4.Салбар дамнасан олон төрлийн хяналтыг нэгдсэн байдлаар төлөвлөж, үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдалд цогц үнэлгээ хийснээр аж ахуйн нэгжийн эрсдэлийг үнэлж, хаах боох биш, зөвлөн туслах замаар үйлчилгээ, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангагдах нөхцөл бүрдэнэ. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгахаар төсөлд, тогтоолын төсөлд тусгасан байгаа гэдгийг хэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд асуулт үгийг нэгтгээд явчихъя. Нэрсээ авчихсан байна. Хэрлэн гишүүн үг хэлье гэж байна.

Б.Хэрлэн: Асуулт, үг 2 хамтдаа. Тэгэхээр энэ дээр 1.1-д энэ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар заасан байна л даа. Тэгээд энэ нь болохоор яг ямар, ямар чиглэлээр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлтүүдийг оруулах юм бэ гэдгийг нэг бүрчлэн зааж хэлсэн байгаад байгаа юм. Тэгэхээр төрийн хяналтын хүрээг оновчилж, хүнс, эрүүл ахуй, эм, эмчилгээний чанар, уул уурхай, газрын тос, байгаль орчин, дэд бүтэц, боловсрол гэх зэрэг гээд ингээд явсан байна. Энд нийтийн ахуй үйлчилгээтэй холбоотой жишээлбэл үсчин, гоо сайхан ч байдаг юм уу тийм ээ, ингээд энэ талын үйлчилгээнүүд дээр бас л хүний эрүүл ахуйтай хамаатай нэлээн олон асуудлууд гарч байдаг. Тэгэхээр энэ тухай нийтийн ахуй үйлчилгээтэй холбоотой ийм зүйлүүд энд тусгагдах уу гэдгийг асуумаар байгаа юм.

Ер нь цаашдаа яг одоо энд хариулах хүн байхгүй бол энэ тухай асуудлуудыг тусгая гэж. Өөрөөр хэлбэл үсчинд хэрэглэж байгаа үсчний будаг ер нь эрүүл ахуйн шаардлага хангаж байна уу, үгүй юү гэдгийг бид хянадаг, шалгадаг байх ёстой байх л даа. Тэр утгаараа энэ бол бас энэ мэргэжлийн хяналтын хяналт шалгалтын асуудалд тусгах ёстой болов уу гэж бодож байна.

2 дугаарт энэ тогтоолын төсөл дотор энэ гуравдугаархад нь тусгагдсан 2026 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн Засгийн газар дахь хяналтын чиг үүрэгт нэгтгэж, төвлөрсөн удирдлагаар энэ мэргэжлийн хяналтын байгууллагыг ахиж шинээр бүрдүүлж, ажиллуулах тухай ийм санаа энэ дээр туссан байгаад байгаа. Тэгэхээр одоо энэ мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаад нэлээн хэдэн жилийн нүүр үзчихэж. Тэгэхээр энэ хууль, эрх зүйн хувьд яг энэ мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх бэлтгэгдсэн боловсон хүчний хувьд эд нарыг нэгтгээд ингээд 1 сарын 1-нээс ингээд ажиллуулахад үнэхээрийн нөхцөл бололцоо бүрдсэн байгаа юу, үгүй юү? Цаг хугацааны хувьд бид 01 сарын 01-ний өдрөөс авч хэрэгжүүлнэ гээд ингээд энэ заасан нь ер нь хэр оновчтой юм бол гэсэн ийм 2 зүйлийг би тодруулж асуух гээд байгаа юм?

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүний асуулт байна. Ер нь энэ тогтоолын төслийн гол зорилго бол нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрх хөндөгдөх аливаа асуудалд л энэ хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр энэ хуулийн төслийг, холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж оруулж ирж, хаврын чуулганаар хэлэлцүүл гэдгийг Засгийн газарт даалгасан ийм нэг дэх заалт байгаа. Тийм учраас таны ярьж байгаа тэр нийтийн аж ахуйтай холбоотой гэдэг юм уу энэ нь өөрөө нийтийн хууль ёсны эрх ашгийг хөндөж байгаа л гэж үзэж байгаа бол энэ хүрээнд оруулах бололцоо, боломж нь байгаа гэж үзэж байна.

Тогтоолын төслийн энэ Засгийн газар дахь хяналт чиг үүргийг нэгтгэж, төвлөрсөн удирдлагаар хангах арга хэмжээг 26 оны 01 сарын 01, энэ өөрчлөгдөх бас байх. Яг 01 сарын 01-нээс одоо намрын чуулган чинь өөрөө бас энэ ондоо багтаж хааж амжихгүй болчихоод байна шүү дээ. Он дамнахаар болчихоод байна. Тийм учраас энэ хугацааг ярьж байгаад, 01 сард бас үргэлжилж намрын чуулган хуралдах байгаа учраас мэдээж 01 сарын 01-ний өдрөөс авч хэрэгжүүлэх энэ

бололцоо боломж, хууль хугацаа, цаг хугацааны хувьд бол бололцоогүй. Тийм учраас энэ хугацаа бас өөрчлөгдөж.

Нөгөө салбарын хяналтууд өнөөдөр яг бас 2 дахь агуулга нь мэргэжлийн хяналтыг шууд татан буулгачихсан гэж болохгүй юм. Салбарын, салбартаа хяналт нь байгаа. Гэхдээ нэгдсэн удирдлага, арга зүйгээр хэн, хаана, яаж хангаж байгаа гэдэг нь тодорхойгүй бүрхэг болчихсон. Ажлаа хэрхэн яаж тайлагнаж байгаа юм, хэний, ямар үүрэг даалгавраар хяналт төлөвлөгөөний дагуу хийгдэж байна вэ гээд ингээд ярихаар асуудлууд байх шиг байна. Тийм учраас Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх энэ агентлагт удирдлагаар хангах, төвлөрүүлэх ийм чиглэлээр цаашдаа энэ хяналтын, төрийн хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр нь ингэж ажиллахаар хуулийн, тогтоолын төсөлд орж ирж байгаа. Амжихаар байгаа юу?

01 сарын 01-ний өдрөөс манай ажлын албаныхан бол референт 01 сарын 01-ний өдрөөс амжина л гэж байна. Амжуулах гээд л хэдүүлээ тогтоолдоо тусгаад оруулъя. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол нэлээн тийм өндөр хүлээлттэй л тогтоол болох нь дээ гэж харж байна. Ялангуяа иргэд, олон нийтийн маш их хүсэж, хүлээдэг олон зүйлүүд энэ тогтоолын төсөл дээр тусгагдсан байна. Энэ дээр жишээ нь Өргөдөл, гомдлын тухай хууль гээд л нэг хууль байгаа. Тухайн хүн ямар ч асуудлаар өргөдөл, гомдол гаргасан 30 хоногийн дотор шийдвэрлэх ёстой гэж байгаа. Би бол энийг даруй 14 хоногт байсан ч болно. Үнэхээр тухайн хүний тавьсан асуудлыг шийдэх боломжтой, боломжгүйг нь шууд хариулах бололцоо аль ч шатны төрийн байгууллагын удирдлагуудад байгаа гэж ингэж хардаг. Эсвэл хаашаагаа ямар өргөдөл гаргах вэ гэдгийг нь заагаад өгдөг ч болдог. Тэгээд энэний жишээ бол саяхан энэ Нямбаатар дарга яриад байна лээ шүү дээ. Аль 6 сард нэг дэлгүүрийн зөвшөөрөл гуйсан, нөгөө дүүргийнхэн нь аль 6 сараас хойш байхгүй. Тэгэхээр энэ бол нэлээн онцгой асуудал, ер нь анхаарах ёстой асуудал юм байна гэж ингэж би боддог.

Нөгөө талдаа ингээд орон нутагт ажиллаж байх үед энэ орон нутгийн аж ахуйн нэгжүүд яах вэ төрийн худалдан авалтын үйл ажиллагаанд ингээд оролцдог. Ялангуяа ингээд хийсэн бүтээсэн ажлынхаа мөнгийг авах гэж бараг 20 орчим гарын үсэг цуглуулдаг. Тэр нь яг ингээд 6, 7, 8 сар дамждаг, ихэнх хүн нь амарчихсан байдаг. Ингээд л ажил удаашраад эхэлдэг ийм зовлонтой. Тэгэхээр ер нь яагаад ингээд 20 гаруй гарын үсэг цуглуулах болчихдог юм бэ гэхээр ер нь төрийн албаныхан аливаа юман дээр гарын үсэг зурахаасаа ер нь жоохон татгалздаг болчихсон. Тэр зурвал би зурна, тэр ингэвэл би ингэнэ, дараа нь асуудал үүсэхэд тэр зурсан учраас би зурсан юм гэдэг нэг ийм хамгаалалт маягийн юм бараг хийхийг хүсдэг болсон учраас энэ шат шатдаа нэг баахан хүний хэрэгтэй, хэрэггүй хүний гарын үсэг цуглуулдаг гүйцэтгэлээ авахын тулд шүү дээ ийм нөхцөл байдал байдаг юм билээ. Би энийг чуулганы хуралдаан дээр бүүр баримттай нь гаргаж ирж байсан. Ажил хийснийхээ төлөө мөнгөө авах гэхээр 20 гаруй гарын үсэг ингээд жирийтэл зуруулж байж нэг юм авдаг гээд. Тэгэхээр энийг эд нар ингээд шинэчлэх нь зүйтэй гэж ингэж боддог.

Сүүлийн үед энэ орон нутагт ажил хийсэн компаниуд өөрсдийнхөө мөнгийг авч чадахгүй байна, тэгээд ингээд төрд гэрээ байгуулаад хийх юмаа хийчихдэг, ингээд хүлээлгэж өгөөд мөнгөө авъя гэхээр мөнгө өгдөггүй. Тэгсэн хэр нь төр болохоор яадаг вэ гэхээр гэрээ байгуулахдаа чи хугацаандаа хийхгүй бол алданги

тооцно шүү гээд ингээд шахаад хийлгэдэг. Хугацаандаа хийчихээр төр өөрөө бизнес эрхлэгчийн өмнө ямар ч хариуцлага хүлээдэггүй. Тэгээд ингээд янз янзын зээл аваад юмаа хийчихдэг, зээлийн тоолуур нь гүйгээд байдаг, хүү нь гүйгээд байдаг. Гэтэл тэр төр мөнгөө өгөөгүйгээс болоод тэр аж ахуйн нэгж өөрөө туйлын хүнд байдалд ордог гэх мэтчилний ийм олон зовлонгууд байгаа.

Тэгэхээр өнөөдрийн энэ тогтоолын төсөл нэлээн хүлээлт өндөртэй ийм зүйл, заалт орсон юм байгаа юм байна, тогтоолын төсөл байна. Тэгээд нэлээн олон хуулиудад ч өөрчлөлт орох юм байна гэж харж байна. Тэгэхээр би үндсэндээ аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааг нь саадгүй явуулах, дэмжих нэг том хууль байх юм байна. Төрийн хүнд суртал гэх үү, энэ зүйлүүдийг багасгах бас нэг хууль явах юм байна. Тэгэхээр энэ асуудлуудыг ярихдаа анхан шатан дээр яг ямар ажил, анхан болон дунд шатан дээр яг ямар ажил асуудлууд, хүндрэлүүд гардаг юм бэ гэдгийг зөв тодорхойлоосой гэж ингэж хүсэж байгаа. Энийг явуулах, энэ тогтоолыг хэрэгжүүлэх энэ боловсон хүчний асуудлыг ч гэсэн бид бодох ёстой ийм зүйл байгаа шүү гэдгийг л би бүүр зориуд хэлье гэж бодож байгаа юм. Зарчмын хувьд дэмжиж байна гэж ингэж хэлье.

Ц.Сандаг-Очир: Идэрбат гишүүн үг хэллээ. Яг таны ярьж байгаатай адилхан яг л энэ бизнесийн, хувийн хэвшлийнхний үйл ажиллагаанд хүндрэл суртал, хүнд суртал, тээг саад болж байгаа, хавчин боож байгаа ийм л үйл ажиллагаанууд амьдрал дээр байгаа учраас энэ үйл ажиллагааг хялбаршуулах, цахимжуулах, ил тод нээлттэй болгох үүднээс л энэ Засгийн газарт энэ чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг өөрчилж, даруй оруулж ир гэдэг ийм агуулгатай энэ тогтоолын 2 дахь агуулга бол энэ байгаа учраас яг амьдрал дээр хүнд суртал болоод байгаа энэ асуудлуудыг түргэн шуурхай болгох үүднээс л энэ тогтоолын 2 дахь агуулгаар ингэж явж байгаа. Тийм учраас Засгийн газар энэ чиглэлүүдээр судалгаа хийгээд, яг хувийн хэвшил, иргэд, бизнес, хуулийн этгээдүүдэд үзүүлж байгаа энэ үйлчилгээнүүд дээр байгаа хүнд суртлуудыг аль болох түргэвчлэх, аль болох түргэн шуурхай болгох чиглэлээр холбогдох хуулийн төслүүдийг оруулж ир гэдэг ийм үүрэг даалгаврыг Засгийн газарт өгч байгаа ийм манай Байнгын хорооны санаачилж хийж байгаа Их Хурлын тогтоол шүү гэдгийг хэлье.

Гишүүд Их Хурлын тогтоолтой холбогдуулж асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Санал хураалт, шууд хураалгаж болох уу заавал бэлдүүлэх үү? Санал хураалтдаа бэлдье гишүүд.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 9 гишүүн дэмжиж, 52,9 хувиар тогтоолын төслийг дэмжлээ. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн, Байнгын хорооны санал, дүгнэлтийг миний бие танилцуулчихъя. Хэлэлцэх асуудал 4 дууслаа.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

5 дахь хэлэлцэх асуудалдаа оръё. Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж, та бүхэнд тараасан. Алив унших уу? Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт, унших шаардлага байна уу гишүүдээ? Байхгүй гэж бүгдээрээ үзэж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг, санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа бэлдсэн бол Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар санал дэмжигдлээ.

17.01 цаг

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

6 дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Би энийг уншихъя. Олон нийтийн радио, телевизийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй байна гэж заасан. Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь 6 жил байх бөгөөд ял шийтгэлгүй, иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон Монгол Улсын иргэнийг гишүүнээр томилох хуулийн зохицуулалттай.

Харин Үндэсний зөвлөлийн гишүүнд төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, бусад радио, телевизэд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход нь оролцдог этгээд, бусад радио, телевизэд хөрөнгө оруулалт хийсэн этгээд, эсхүл олон нийтийн радио, телевизийн санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж болох этгээдийг нэр дэвшүүлэхгүй.

Монгол Улсын Их Хурал нь олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага болох Үндэсний зөвлөлийн гишүүнд 7 хүнийг нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд Улсын Их Хурлаас нэр дэвшүүлж, томилсон 7 гишүүний 3 гишүүний бүрэн эрхийн хугацаа 25 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр дуусгавар болсон. Иймд Олон нийтийн радио, телевизийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт заасны дагуу холбогдох төрийн бус байгууллагууд, эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд санал болгох хуулийн зохицуулалттай.

Мөн тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэгт энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэсний дагуу Улсын Их Хуралд холбогдох төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналаас сонголт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах шаардлага гарсан тул Төрийн байгуулалтын байнгын хороо Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэн батлах юм.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.8 дахь заалт хэсэгт Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурал нэр

дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж, зөвлөлийн гишүүнээр томилохоор тус тус заасан тул Төрийн байгуулалтын байнгын хороо холбогдох төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналаас сонгон шалгаруулалт хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг Байнгын хорооны гишүүддээ танилцуулж байна.

Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүн байна уу? Лодойсамбуу гишүүн үг хэлье гэж байна. Микрофоныг нь өгье.

Ч.Лодойсамбуу: Байнгын хорооны даргаа энэ ажлын хэсэгт орох хүсэлтэй байгаагаа илэрхийлж байна. Хүсэлтийг маань шийдвэрлэж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэгт үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг төрийн бус байгууллагуудын саналаас сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч ахлагчаар Б.Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн гишүүнд Э.Болормаа, А.Ганбаатар, Ц.Идэрбат, Г.Уянгахишиг гишүүн, Ч.Лодойсамбуу гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг Ажлын хэсэг Б.Баярбаатарт зөвшөөрсүгэй гэсэн. Тогтоолын төслөөс асууж тодруулах зүйл гишүүд байна уу? Байхгүй байна. Санал хураалтдаа бэлдье гишүүд.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя гишүүдээ. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар санал дэмжигдлээ. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

17.06 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаа идэвхтэй ирсэн Хэрлэн, Уянгахишиг гишүүн, Зулпхар гишүүн, Баярбаатар гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Номин гишүүн, Энхтуяа гишүүн, Баярмаа гишүүн, Даваасүрэн гишүүн, өөр хэн байлаа, Шижир гишүүн, өөр хүний нэр орхичхоогүй байгаа, Номин гишүүн, Учрал гишүүн, Идэрбат гишүүн нартаа баярлалаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА